



- ✓ Томоохон ESL сургуулиудын нэг
- ✓ 2300+ мэргэшсэн багш нар
- ✓ Өдөр тутамд харгалзах багш
- ✓ Шууд хэрэглэж болох практик сургалт
- ✓ Хичээлийг шууд хянах боломж
- ✓ Тусгай далайн эрэг



Practical courses



TESOL qualified



School nurse



24 hours security



High-class gym



High-class swimming pool



Multiple Accommodation



Beach life



International staff



Activities



Room cleaning



Laundry service



international@qqeng.com



www.qqeng.net



-CampusTop-
QQ English



BEACH FRONT
CAMPUS

IT PARK
CAMPUS

REAL GREATENGLISH CORPORATION (QQEnglish)

Байгуулагдсан
он

2009

Ажилтны тоо



2500+

(Гадаад ажилчдыг оруулаад)

Үйлчилгээ

Өвөл, зуны кемпын аялал, эцэг эх, хүүхдийн
хамтын сургалт, ESL сургалт, гадаадад сурахад
бэлтгэх, онлайн сургалт

QQEnglish BFC Кампус



QQEnglish Beach Front Кампус (BFC) нь Лапу-Лапу хотын Мактан Ньютаунд байрладаг, Мактан ОУ-ын нисэх онгоцны буудлаас ердөө 19 минутын зайтай.

Мактан Ньютаун нь Филиппиний орон сууц, худалдаа, үзвэр үйлчилгээ, аялал жуулчлалын байгууламжуудыг нэгтгэсэн томоохон хот байгуулалтын төсөл бөгөөд жуулчдын сонирхлыг татдаг алдартай аялал жуулчлалын газар юм.



Beach Front Кампус нь Мактан Ньютауны зүрхэн хэсэгт байрладаг! Манай сургууль нь 14 давхар, 12,000 орчим метр квадрат талбайг эзэлнэ.

Сургуулийн байгууламжид оффис, суралцах хэсэг, чөлөөт цаг өнгөрүүлэх хэсэг зэрэг таны хэрэгцээт бүхий л байгууламж багтсан. Түүнчлэн 1300 гаруй багш, 600 суралцагчдын дотуур байр ч бий!



Гадаах орчин цэвэрхэн. Амины орон сууц, зочид буудал, ресорт, далайн эрэг, ресторан, шөнийн зах, хүнсний дэлгүүр, автобусны буудалтайгаа ойрхон байдаг тул таны энд байх хугацаа таатай өнгөрөх болно.





- 2,300 багш нартай. Бүгд TESOL зэрэгтэй.
- Бүх багш нар коллеж ба түүнээс дээш түвшний боловсролтой мэргэшсэн ажилтнууд байдаг.
- Чанартай багш бэлтгэх үүднээс багш нар дөрвөн удаагийн шалгалтад орохоос гадна дөрвөн долоо хоногийн сургалтад хамрагддаг.
- Манай сургалтын чанарыг хамгийн дээд түвшинд хүргэхийн тулд бүх багш нар сар, улирал бүр тогтмол сургалтад хамрагдаж, сурагчдын үнэлгээ зэргийг багтаасан үнэлгээ хийлгэдэг.
- Сургалтын чанарыг бататгахын тулд бүх багш нар улирал бүр тушаал дэвших үнэлгээг хийлгэдэг.

Кемпын онцлог

Сурагчдын нас:

Өсвөр нас (10-17 нас)

Гэр бүл (5-17 нас)



QQEnglish сонгох шалтгаан:

1. Өдөр тутам хариуцах багш нар (DLT):

DLT нар нь сурагчдыг өдрийн цагаар хичээлд нь хүргэж өгөх, хоолонд оруулах, шөнийн цагаар сайн унтаж амарч буй эсэхийг шалгах болон сурагчдын ерөнхий эрүүл мэндэд анхаарч ажилладаг.

10 ба түүнээс дээш насны сурагчдад: Зургаан сурагч тутамд 1 DLT.

5-9 насны сурагч: Хоёр хүүхэд тутамтд 1 DLT.

2. Тухайн хичээлийн цагаар хянах боломжтой тусгай Аппликэйшнтэй. Та гэрээсээ хүүхдийнхээ үзэж буй хичээлийг хянах боломжтой.

3. Хичээлүүд сурагчдын хэлний чадварыг дээшлүүлэх, практикт ашиглах, болон сургалтын дараа ч ашиглах боломжтой байдлаар төлөвлөгдсөн.





Хичээлийн зохион байгуулалт

Хичээл

-4 ганцаарчилсан хичээл

Англи хэлний ур чадварыг системтэйгээр сайжруулахын тулд хичээлийг сурагчийн англи хэлний түвшин, сургалтын зорилгод нь тохируулна.

-2 групп хичээл

5~6 нас:


Хичээлийг харилцах боломжтой, сонирхолтой байлгахад анхаарч, сурагчийн анхаарлыг татах, англи хэлд сонирхолтой болгох, сурах үйл явцыг таатай байлгахад анхаарна.

7~17 нас:

Нөхцөлд суурилсан сургалт, өдөр тутмын практик үйл ажиллагаатай холбоотой (зочид буудал, нисэх онгоцны буудал, ресторан, худалдааны төв, лекц г.м) хичээлийн агуулгатай бөгөөд суралцсан даруйдаа өдөр тутмын амьдралдаа ашиглах боломжтой.

-Оройн бие даан суралцах цаг

Өдөр бүр нэг цаг бие даан суралцах цагаар тухайн өдөр суралцсан зүйлээ давтах боломжтой бөгөөд харгалзах багшаас хүссэн асуултын хариугаа авч болно.



Хичээлийн хуваарийн жишээ



–CampusTop–
QQ English

CampusTop Өвлийн Кемп

Цаг	Даваа - Баасан	Бямба	Ням
07:40-08:10	Өглөөний дасгал	Чөлөөт цаг эсвэл Сургуулийн аялал	Чөлөөт цаг
08:10-08:50	Өглөөний цай		
09:00-09:50	Жижиг групп (өдөр тутмын Англи хэл)		
10:00-10:50	1 VS 1 (бүх ур чадвар)		
11:00-11:50	1 VS 1 (ярих)		
12:00-14:00	Өдрийн хоол		Өдрийн хоол
14:00-14:50	1 VS 1 (унших)		Чөлөөт үйл ажиллагаа
15:00-15:50	1 VS 1 (бичих)		
16:00-16:50	Жижиг групп (яриа / бүх чадварын)		
17:00-18:50	Оройн хоол		
19:00-20:00	Оройн хичээл (гэрийн даалгавар)	Амрах цаг	
20:00 дараа	Унтах цаг		

Анхаарах:

- Өдрийн хоолны цаг 11:00 - 14:00 хооронд үргэлжилнэ.
- Дээрх цагийн хуваарь нь зөвхөн жишиг бөгөөд хичээлүүд дээрх цагийн дагуу хуваарилагдана.



international@qqeng.com








www.qqeng.net





–CampusTop–
QQ English



QQEnglish сургуулийн хоёр давхар, олон зориулалт бүхий танхим нь хүлээн авах хэсэг, оффисын өрөө, ресторан, чөлөөт цаг өнгөрүүлэх хэсэг, номын сан зэрэг төрөл бүрээр ашиглагдах боломжтой. Хичээлийн дараа сурагчид энэ хэсэгт чөлөөт цагаа ая тухай өнгөрүүлж болно. Хоолоо амтархан зооглож, найзуудтайгаа ярилцаж, ном уншиж, хичээлийн дараа амрах зэрэгт энэхүү танхим төгс зохицно.








Сургуулийн барилгын 4, 5-р давхарт сурагчид чимээгүй, тухтай орчинд хичээллэх боломжтой сургалтын хэсэг байрлана. Эдгээр давхрууд нь онлайн хичээлээс бүрэн тусгаарлагдсан тул сурагчид багштайгаа харилцах, төвлөрөх боломжийг олгодог. Танхимын хичээл, бүлгийн хичээл эсвэл практик үйл ажиллагаа зэрэг аль нь ч байсан энэхүү сургалтын байр нь сурагчдын сурах хэрэгцээг хангаж, суралцах таатай уур амьсгал, нөхцлийг бүрдүүлнэ.

Сургалтын бүс






Savoy Зочид буудал



- Сэбү дэх шинэ зочид буудлуудын нэг. Амралт зугаалга, ажил хэргийн зориулалт бүхий иж бүрэн тавилгатай 547 өрөөтэй.
- Дотор болон задгай суудалтай хоолны газруудтай. Мөн иж бүрэн тоноглогдсон биеийн тамирын заал, хотхоны гайхалтай үзэмжийг харуулах гадаа усан сан байдаг.
- Үзэсгэлэнт, цэлгэр далайн эрэг нь амралтаа зугаатай өнгөрүүлэх боломжийг танд олгоно.

Mactan Newtown далайн эрэг




Мactan Newtown эрэг



- Мactan Newtown бол Метро Манилагийн гаднах Мегаворлддын хамгийн том бүтээн байгуулалт билээ. Филиппиний өөрийн гэсэн далайн эрэгтэй хамгийн анхны цогц төлөвлөгдсөн хороолол юм.
- Олон хүний хувьд энэ газар нь мөрөөдлөө биелүүлсэн газар болдог. Орчин үеийн дэвшилтэт оффисын барилгууд, сайн зохион байгуулалттай худалдааны төв, дээд зэрэглэлийн зочид буудал, сургалтын байгууллага, далайн эрэг зэргийг төгс хослуулсан газар юм.

Эргэн тойронд



- Ресторан, супермаркет, чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжтой газрууд бүгд нээлттэй.



Хоорондоо тохирсон баялаг, жор, амттай

Хүүхдийн тоглоомын өрөө



Завсарлагааны цагаар хүүхдүүдийг чөлөөт цагаа
өнгөрүүлэхэд зориулсан хүүхдийн тоглоомын өрөө

Сурагчдын эрүүл мэнд




-CampusTop-
QQ English

24-цагийн резидент сувилагч



- Сургуулийн сувилагч, эмч нар үргэлж сурагчдын эрүүл мэндийн хэрэгцээнд анхаардаг.
- Тусгай зөвлөгөө өгөх эрүүл мэндийн мэргэжилтнүүд тогтмол сургуулиар зочилдог.

Яаралтай тусламжийн эмнэлэг



Allegiant Regional Care эмнэлэг

Утас: +63(032) 260 9189

Хаяг: Allegiant Regional Care эмнэлэг, Лапу-Лапу, 6015 Сэбү



international@qqeng.com




www.qqeng.net



-CampusTop-
QQ English

Өдөр тутмын асрагч багш нартай хамт



Өдөр тутмын асрагч багш нар сургуулийн байранд 24 цаг хамт байж, сурагч нартайгаа ижил дотуур байранд амьдарч, сурагчдын хэрэгцээг үргэлж сонсоно.

Олон улсын ажилтан



Манай олон улсын ажилтнууд бүх сурагчдыг ая тухтай байлгахын тулд тусламж, дэмжлэг үзүүлдэг!


Хэл: Япон, Хятад, Монгол, Вьетнам, Араб, Тайланд, Орос.

24-цагийн харуул хамгаалалт




- Бүх сурагчдын аюулгүй байдлыг хангах 24 цагийн харуул хамгаалалт.
- Кемпын үеэр хатуу дүрэм баримталж, барилгад нэвтрэх дүрмийг дагана. Хамгаалалтын ажилтнууд сургуулийн барилгын хаалга, дотуур байрны орчимд байрлана.
- ID картгүй бол оруулахгүй.

Хичээлийн үеэр



Гадуур үйл



Төгсөлтийн баяр



Бусад үйл ажиллагаа



Чухал анхааруулга

Өөрийн гэсэн эмтэй байх:

1. Цагаар эм уух шаардлагатай сурагчид урьдчилан бэлдэж, эмээ биедээ авч ирэх.
2. Ханиад, суулгалтын эм, өвчин намдаах эм зэргийг бэлтгэх.
3. Бүх эмийн хэрэглээг ойлгомжтой бичиж авчрах.

Даатгал:

Аялал, эрүүл мэндийн даатгалыг урьдчилан хийлгэхийг зөвлөж байна.

Харшил:

Сурагч ямар нэг хоол, өөр нэг зүйлээс харшилтай бол бүртгүүлэхдээ мэдэгдэх.

Хувцаслалтын зөвлөмж:

1. Филиппины цаг агаарын дундаж хэм 27°C байдаг. Сурагчид долоо хоногийн солих хувцас бэлдэхийг зөвлөж байна. Сургуулиас долоо хоног бүр угаалгын үйлчилгээ үзүүлнэ.
2. Хичээлийн танхим, худалдааны төв, заал болон бусад олон нийтийн газруудад агааржуулагчтай байдаг тул гаднах, доторх хэмийн ялгаа их. Ханиад хүрэхгүйн тулд гадуур хүрэм авчрахыг зөвлөж байна.
3. Кемпын үеэр усан үйл ажиллагаа зохион байгуулна. Сурагчдыг сэлэхэд зориулж хувцас, гутал, усны алчуур бэлдэнэ үү.
4. Кемпын үеэр спортын үйл ажиллагаа зохион байгуулах боломжтой. Сул биеийн тамирын хувцас, чөлөөт хувцас, тухтай гутал зэргийг мөн бэлдэнэ үү.

